

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ | ЗОРИГЖУУЛНА | МЭДЭЛЖҮҮЛНЭ

Пүрэв, 2019.11.21, №8 (124)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.com

WEEKLY



ДеФакто **НИЙТЛЭЛ**
№505

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

ШХАБ-ЫГ АЖИГЛАХ НЬ

ДеФакто **ТОЙМ**

➤ МОНГОЛ УЛС ҮНДСЭН ХУУЛИА ШИНЭЧЛЭН БАТАЛЛАА

Монгол улсын Үндсэн хууль 6 бүлэг, 70 зүйлтэй бөгөөд үүний 19 зүйл, 36 заалтад нь өөрчлөлт орууллаа. Улсын Их Хурлын чуулганы 2019.11.14-ний өдрийн 18:02 цагт Монгол улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг чуулганы хуралдаанд оролцсон 63 гишүүний 100 хувийн саналаар баталлаа.

➤ СУРГУУЛИЙН АВТОБУС ЯВЖ ЭХЭЛЛЭЭ



➤ 2020 ОНЫ ТӨСӨВ 2 ИХ НАЯД ТӨГРӨГИЙН АЛДАГДАЛТАЙ БАТЛАГДЛАА

IV НҮҮРТ



Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллагад (ШХАБ) Монгол улс ажиглагчаар оролцоод 15 жил болж байна. ШХАБ-ыг санаачлан байгуулсан, шийдвэр гаргахад нь хамгийн их нөлөөлдөг хоёр хөрш маань монголыг жинхэнэ гишүүнээр элсэхийг санал болгоод удаж байна. Монголын төр засгийн удирдлага элсэх сонирхлоо илэрхийлэх болсон ч, манайх шиг ардчилсан оронд эцсийн шийдвэрийг иргэдийн дэмжлэггүйгээр гаргах боломжгүй. Учир нь төр засгийн аливаа шийдвэрийг иргэд хүлээн зөвшөөрөхгүй байвал дараагийн сонгуулиар төр засгаа өөрсдийг нь сольж болдог улс. Тийм ч учраас энэ байгууллагад элсэх нь ямар үр дагавар, сорилт авч ирэх, яагаад бид яаравчлах ёстой гэдгийг иргэд, тэдний дуу хоолой болсон иргэний нийгэм нь бүрэн ойлгох хүртэл цөөн жилийн настай төр засаг нь ямар ч алхам хийх боломжгүй. Тэгээд ч манай улс хойд, урд хоёр хөрштэй стратегийн иж бүрэн түншлэлтэй гэж тунхаглаад байгаа ч, яагаад ганц ч том төсөл хэрэгжихгүй арваад жил болж байгаа нь иргэдийн гайхал, эргэлзээг төрүүлж, итгэлийг бууруулж байна.

Монгол улс дэлхийн хоёр их гүрний дунд байгаа том нутагтай ч, цөөхөн хүнтэй жоохон улс. Бидний хувьд эдийн засгийн аюулгүй байдал хамгийн чухал. Хоёр талын болон гурван талын харилцаан дээрээ тодорхой ямар ч ажил хийж чадахгүй байгаа мөртлөө, олон талын харилцаанаас буюу аль нэг бүс нутгийн байгууллагад элсээд орчихоор л тодорхой үр дүн гарна гэдэгт итгэхэд улам хэцүү болсоор байна.



▶ ШХАБ-ЫН ТЭЛЭЛТ БА СОРИЛТ

1990 онд ЗХУ задран унахад бий болсон Дундад Азийн шинэ улсууд “хилийн нутгаараа цэргийн итгэлцлийг бэхжүүлэх” шаардлагаас угшилтай ШХАБ нь эдүгээ 8 гишүүн, 4 ажиглагч, 6 яриа хэлэлцээний түнштэй буюу 18 орны төрийн удирдлага жил бүр уулздаг, томоохон бүлэглэл болжээ. Анхдагч зорилго нь Евро-Азийн бүс нутгийн аюулгүй байдлыг хангах, юуны өмнө гурван аюул буюу хүчирхийлэл, салан тусгаарлал, хэт туйлшрах үйлдэлтэй (terrorism, separatism, extremism) тэмцэх байсан бол эдүгээ эдийн засгийн олон талын хамтын ажиллагааг хөгжүүлэхийг зорьж байна.

Харин бодит амьдрал дээр Хятадын санаачилсан, дангаараа зээл өгч санхүүжүүлдэг “Зам ба Бүс” төслөөс өөр бодитой ажил бараг хийгээгүй байна. Гурван аюултай тэмцэх (RATS) төвөөрөө дамжуулан тагнуулын мэдээллээ ч бүрэн хуваалцахгүй байгаа ажээ. Терроризмийн тодорхойлолт дээр гишүүд нь нэгдсэн байр сууринд хүрээгүй байна. Энэтхэг, Пакистан орж ирснээр, ялангуяа Энэтхэг хүн амын дийлэнх нь ислам Жаму-Кашмирийн автономит эрхийг саяхан цуцлаж, цэргийн хүчээр захирах болсон нь энэ тодорхойлолтын зөрөөг улам өсгөж эхэллээ.

МОНГОЛЫН БАЙР СУУРЬ ӨӨРЧЛӨГДӨХ ҮҮ?

ШХАБ бол Хятад, Оросын хослол удирдан чиглүүлдэг байгууллага. Дэлхийн хамгийн том, ардчилсан, цэрэг дайны хүчтэй их гүрэн Энэтхэг орсноор байдал яаж өөрчлөгдөхийг ажиглах хэрэгтэй. Эхний ээлжинд байгууллагын албан ёсны хэл Хятад, Орос дээр нэмж Англи хэлийг оруулах Энэтхэгийн саналыг яаж хүлээж авах нь сонин байна. Энэ бол Афганистан, Иран улсын хувьд жинхэнэ гишүүнээр орох, идэвхтэй ажиллахад бас нэг хүчин зүйл. Хэрэв Иран ШХАБ-д элсэх аваас Орос, Хятад, Энэтхэгтэй хамтарсан улс төрийн

Энэтхэг Орос хоёр бол цэргийн уламжлалт түншүүд. АНУ-ын эсэргүүцлийг үл харгалзан Оросын агаарын хамгаалалтын S-400 пуужинг худалдаж авсан. Одоо болтол Энэтхэгийн цэргийн зэвсгийн дийлэнх нь Орос. Энэтхэгт Оросын барьсан зургаан цөмийн цахилгаан

Гишүүн	Ажиглагч	Яриа хэлэлцээний түнш
Казакстан	Афганистан	Азербайжан
Киргиз	Беларус	Армени
Пакистан	Иран	Камбожи
Орос	Монгол	Непал
Тажикстан		Турк
Узбекстан		Шри Ланка
Хятад		
Энэтхэг		

станц ашиглалтанд орох гэж байгаа бөгөөд нэмж зургааг барихаар саяхан Владивостокд гэрээг үзэглэсэн.

Пакистан, Хятад хоёр илүү ойрхон түншүүд. 1947 оноос хойш Энэтхэгтэй булаацалдаж, маргаантай байгаа Кашмирийн газар нутгаас 1962 онд Хятадад таслан өгсөн. Орос Энэтхэгийг, Хятад Пакистаныг дэмжин ШХАБ-д зэрэг оруулсан гэж үздэг.

Энэтхэг жилд 7 хувиар өсч буй эдийн засаг нь эрчим хүчний хомсдолтой учир Төв Ази, Оросын байгалийн хий, газрын тосны нөөцтэй холбогдох, цаашдаа Евро-

Азийн эдийн засгийн холбоонд ч орох сонирхолтой учир ШХАБ-д элсэх нь практик ач холбогдолтой. Хятад бол Энэтхэгийн уламжлалт өрсөлдөгч. Хятадын “Зам ба Бүс” төслийг эдийн засгаа тэлэх бодлого, нээлттэй биш хөтөлбөрүүд гэж үздэг учир ШХАБ дээр энэ төслийн тухай ярилцахыг таашаахгүй байгаа. Энэтхэг нь АНУ, Австрали, Японтой байгуулсан дөрвөн талын гэрээгээр далайн тээврийн тасралтгүй урсгалыг хамгаалах үүрэгтэй. Энэ улсууд Хятадын Номхон далайн маргаантай арал дээр цэргийн бааз байгуулсныг эсэргүүцэж байгаа. Энэтхэг улсыг нэг хөл нь Хятад, нөгөө хөл нь АНУ залсан завин дээр зэрэг зогсох боллоо гэж судлаач Atul Bhardwaj зүйрлэжээ. Гэтэл тэр хоёр завь ойртож биш холдож байгааг геополитикийн ноёрхлын төлөө тэмцэлдэж буй энэ хоёр том гүрний хооронд эдүгээ ид өрнөж байгаа худалдаа, технологийн дайн харуулж байна.

Орос болон АНУ, Европын орнуудын харилцаа, ялангуяа Оросын эсрэг эдийн засгийн хорио нь, газрын тосны зах зээлийн үнээс хамаардаг эдийн засагт нь нэмэлт дарамт болж рублийн ханшийг тогтворгүй болгож, улмаар иргэдийнх нь амьдралын түвшинд мэдэгдэхүйц сөргөөр нөлөөлөх болжээ.

дэлхийн хамгийн том эвсэл болно.

Олон туйлтай болж буй дэлхийн газрын зураг дээр, манайх шиг жижиг орон аль нэг талд нь түрүүлж орохыг яарах шаардлагагүй. Энэ бол их хөрөнгө мөнгөтэй, хүчирхэг эдийн засаг, цэрэг армитай том гүрнүүдийн ажил. Нөгөө талаасаа Монголын эдийн засаг жижгээс гадна, улс төр тогтворгүй, төр засаг ойрхон солигдож байгаа нь урт хугацааны шийдвэр гаргах нөхцөл байдал бүрдээгүйг харуулж байна. Тэгээд ч Монголын хувийн хэвшил жижиг, бүсийн түвшинд бизнес эрхэлж

эхлээгүй байна. Монгол улс ШХАБ-д элсэх шийдвэр гаргахын өмнө өргөн хүрээнд, олон талаас нь хэлэлцүүлгээ үргэлжлүүлэн явуулах нь зөв. Харин тэр болтол хоёр хөрштэйгээ эдийн засаг, байгаль орчин, хар тамхитай тэмцэх талаар хамтран ажиллах хоёр талын болон гурван талын механизмаа өгөөжтэй ажилуулах, ШХАБ-ын ажиглагч гишүүний цар хүрээ, боломжийг бүрэн ашиглаж, боломжтой бүх талаар хамтран ажиллах, боловсон хүчнээ сургахад анхаарах хэрэгтэй.

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ | ЗОРИГЖУУЛНА | МЭДЭЛЖҮҮЛНЭ

ДАВАА ГАРАГ БҮР



НЭГ УЛИРЛЫН ҮНЭ
30.000₮

МОНГОЛ ШУУДАН
7007-8916

WWW.MONGOLPOST.MN



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2019.11.17-ны дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

МОНГОЛ УЛС ҮНДСЭН ХУУЛИА ШИНЭЧЛЭН БАТАЛЛАА

Монгол улсын Үндсэн хууль 6 бүлэг, 70 зүйлтэй бөгөөд үүний 19 зүйл, 36 заалтад нь өөрчлөлт орууллаа. Улсын Их Хурлын чуулганы 2019.11.14-ний өдрийн 18:02 цагт Монгол улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг чуулганы хуралдаанд оролцсон 63 гишүүний 100 хувийн саналаар баталлаа.

Монгол улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл эцэслэн батлагдсантай холбогду Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Хорь гаруй жил яригдаж, сүүлийн 3 парламент дамжин идэвхтэй өрнөсөн, 4 төсөл өргөн баригдсан Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулж, ирээдүйн зам мөрөө тэгшлэн засах олон жилийн, олон хүний хүсэл эрмэлзэл ажил хэрэг боллоо” гэж хэлэв.



ҮНДСЭН ХУУЛИЙН ӨӨРЧЛӨГДСӨН ОНЦЛОХ ЗААЛТУУДЫГ ТАНИЛЦУУЛЖ БАЙНА.

Өмнөх хувилбар 6.2. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн.

Шинэ хувилбар 6.2. “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн.

Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрт эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

Өмнөх хувилбар 21.4. Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно.

Шинэ хувилбар 21.4. Улсын Их Хурлын сонгуулийг журмыг хуулиар тогтооно. Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.

Өмнөх хувилбар 22.2. Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр буюу эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн санал болгосноор өөрөө тарах шийдвэр гаргаж болно. Ийнхүү тарах шийдвэр гаргасан бол шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ эдэлнэ.

Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш 45 хоногийн дотор Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй бол өөрөө тарах буюу эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах тухай шийдвэр гаргана.

Шинэ хувилбар 22.2. Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзэж, эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөж санал болгосон бол Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар өөрөө тарах шийдвэр гаргаж болно.

Өмнөх хувилбар 25.1.16. Ард нийтийн санал асуулга явуулах. Сонгуулийн эрх бүхий иргэдийн олонх нь оролцсон ард нийтийн санал асуулгыг хүчинтэйд тооцож, олонхын санал авсан асуудлыг шийдвэрлэгдсэн гэж үзнэ.

Шинэ хувилбар 25.1.16. Ард нийтийн санал асуулга явуулах. Сонгуулийн эрх бүхий иргэдийн олонх нь оролцсон ард нийтийн санал асуулгыг хүчинтэйд тооцож, олонхын санал авсан асуудлыг шийдвэрлэгдсэн гэж үзнэ.

Монгол Улс өөрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх аливаа оролдлогыг үл зөвшөөрөх бөгөөд ийм зорилгоор ард нийтийн санал асуулга явуулахыг хориглоно.

Өмнөх хувилбар 26.1. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдэлнэ.

Шинэ хувилбар 26.1. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтооно.

Өмнөх хувилбар 27.2. Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа 50-аас доошгүй ажлын өдөр чуулна.

Шинэ хувилбар 27.2. Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа 75-аас доошгүй ажлын өдөр чуулна.

Өмнөх хувилбар 29.3. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.

Шинэ хувилбар 29.3. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.

Өмнөх хувилбар 30.2. Ерөнхийлөгчөөр 45 нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.

Шинэ хувилбар 30.2. Ерөнхийлөгчөөр 50 нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно.

Өмнөх хувилбар: 43.2. Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагас нь нэгэн зэрэг огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.

Шинэ хувилбар: 43.2. Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.



ДеФакто **ТОЙМ**

Улс төрийн намтай холбоотой тухайлсан заалт Үндсэн хуульд байгаагүй бол нам Үндсэн хуульд заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллах, намыг Монгол улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулахаар тусгасан. Энэ заалтыг 2028 оны 1-р сарын 1-ний өдрөөс мөрдөж эхлэхээр Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулиар тусгайлан зохицуулсан байна. Түүнчлэн намын санхүүжилт ил тод байх, үйл ажиллагаа нь үндсэн чиглэл, үзэл баримтлалтайгаа нийцсэн байхаар тусгасан ба үүнтэй нийцүүлэн Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэн найруулж батална.

Түүнчлэн “давхар дээл”-ийг тайлж, Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүн байхаар хязгаарлалт тогтоож, Улсын Их Хурлаар томилогдсон Ерөнхий сайд танхимын гишүүдээ өөрөө томилж, чөлөөлж, огцруулдаг байх зохицуулалт орлоо.

Улсын Их Хурал улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно, харин ингэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж болохгүй.

Мөн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэг, түүний эрх зүйн байдалтай холбогдох хууль тогтоомжийг баталсны үндсэн дээр Засгийн газар Дархан, Эрдэнэтийг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг



2020 оны эхний хагас жилд багтаан шийдвэрлэнэ.

Монгол улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2020 оны 5-р сарын 25-ны өдрийн 12.00 цагаас эхлэн улс орон даяар мөрдөж эхэлнэ. Монгол улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэлх хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг баримтална. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж дуусгана.

Гэхдээ сонгуулийн холимог тогтолцоог Үндсэн хуульд тусгах саналыг дэмжилгүй унагасныг эсэргүүцэн АН-ын зөвлөлийн гишүүд болон МАХН-аас сонгогдсон О.Баасанхүү нар төслийг батлахаас өмнө чуулганы танхимыг орхиж гарсныг тэмдэглэх хэрэгтэй.

СУРГУУЛИЙН АВТОБУС ЯВЖ ЭХЭЛЛЭЭ



Улаанбаатар хотод 1.6 сая хүн амьдарч байгаагаас 1.2 сая нь ямар нэгэн байдлаар замын хөдөлгөөнд оролцож, 500 мянга гаруй машин замын хөдөлгөөнд оролцдог. Нийслэлийн Засаг даргын захирамжаар авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор “Сургуулийн автобус”-ыг туршилтаар явуулж эхлээд байна. Эхний ээлжинд Ерөнхий боловсролын 29 сургуулийн 3000 гаруй хоёроос тавдугаар ангийн сурагчдыг хоёр ээлжээр гэр, сургууль гэсэн маршрутаар зөөнө. Сурагчдыг автобусанд нийгмийн ажилтан

харгалзаж явна гэж байгаа. Сургуулийн автобус нь сурагчдыг өглөө, өдөр, орой хичээл эхлэх болон тарах цагуудад үйлчлэх бөгөөд дээрх автобусуудыг хаягжуулан, хяналтын төхөөрөмж суурилуулж, техникийн аюулгүй байдлыг хангуулах зэрэг ажлыг хийжээ. Энэ ажлыг эхлүүлснээр хотын ачаалал түгжрэлийг бууруулах, цаг хугацаа, зардал хэмнэх зэрэг олон асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой. 3000 хүүхэд гэдэг чинь бараг л 3000 машин болж таарах гээд байгаа. Мөн нөгөө талаасаа монголын сургуулиудын чанарын түвшин харилцан адилгүй, хол зөрөөтэй болсныг харуулж байна. Боловсролын систем 2 өөр хүмүүс бэлдээд эхэлчихсэн шүү.

2020 ОНЫ ТӨСӨВ 2 ИХ НАЯД ТӨГРӨГИЙН АЛДАГДАЛТАЙ БАТЛАГДЛАА

Монгол улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээг 2020-2022 онд 6.0 хувь байхаар төлөвлөжээ.

	2020	2021	2022
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого	11 их наяд 797.8 тэрбум төгрөг	12 их наяд 826.7 тэрбум төгрөг	13 их наяд 773.6 тэрбум төгрөг
Нийт зарлагын дээд хэмжээ	13 их наяд 872.6 тэрбум төгрөг	14 их наяд 89.7 тэрбум төгрөг	14 их наяд 502.4 тэрбум төгрөг
Нэгдсэн төсвийн алдагдал	2 их наяд 74.7 тэрбум төгрөг	1 их наяд 262.9 тэрбум төгрөг	728.9 тэрбум төгрөг

2016 онтой харьцуулвал төсвийн алдагдал багасч байгаа. Гэхдээ 2020 он сонгуулийн жил учраас сонгуулийн төсөв л харагдаж байна. Ер нь төрийн

үүрэг юу билээ, хөнжлийнхөө хэрээр хөлөө жийж чадаж байна уу, төрийн хийж байгаа зүйлийн үр дүнд ажлын байр бий болж байна уу, хувийн хэвшил өрсөлдөх чадвартай болж байна уу гэх мэтээр ажиглах хэрэгтэй байна.

Төсвийн орлогын 80 хувь татвараас бүрддэг. Нийгмийн даатгалын шимтгэл нэмээд, татвар нэмээд л байдаг, гэтэл цаана нь татварын өчнөөн тэрбум төгрөгийг нь аль нэг банкинд хадгалуулаад, банк нь дампуураад алдчихсан байдаг. Төр засаг татвараа авсан, тэгээд авсан татвараа хулгайд алдаад байдаг. Энэ чинь ямар учиртай юм бэ?

Төсвийн сахилга бат муу хэвээр байгаа. Төсвөөс санхүүжүүлж байгаа төслүүд дотор их хурлын гишүүдтэй холбоотой компани байна уу, үгүй юу гэдгийг харах ёстой. Хамгийн наад зах нь сургууль цэцэрлэг барих төсөв тийм хэмжээтэй байна гэсэн жишиг байгаа юу гэдгийг бодох ёстой.

*Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв
Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вебсайтаас үзэх боломжтой.*

Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com
☎ +976 94109342
🌐 www.defacto.mn
www.jargaldefacto.com